

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

А.Энхбат*, Г.Янжинсүрэн**2

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын төсөв, санхүүгийн ил тод байдлыг бий болгох, иргэдэд улсын төсөв, санхүүгийн хөрөнгийг Засгийн газар, төрийн байгууллагууд хэрхэн үр ашигтай захиран зарцуулж байгаа мэдээллийг хүргэхэд чухал ач холбогдолтой эрх зүйн зохицуулалт болох “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судлан, шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, цаашид энэ хуулийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарах асуудлын талаар санал, дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.

Түлхүүр үгс: - Шилэн данс, шилэн дансны мэдээллийн нэгдсэн цахим хуудас-www.shilendans.gov.mn, улсын төсөв, орон нутгийн төсөв, төрийн худалдан авах ажиллагаа, төсвийн байгууллагууд

Abstract: In the framework of this study, we have reviewed the transferency of state finance and budget of Mongolia and studied the implementation and preliminary results of the Glass account law and made analysis on the present situation of Glass account law and made some conclusions and recommendations on implementation of law.

Keywords: Glass account, website of glass account -www.shilendans.gov.mn, state budget, local budget, public procurement, budget entitie's.

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) enkhbatamarjargal@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) Yanjinsuren_g@mof.gov.mn

Удиртгал

Шилэн дансны тухай хуулийн зорилго нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжих аливаа байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо нь ил болгох, хэн хэдий хэмжээний мөнгийг чухам юунд зарцуулав гэдгийг тухайн байгууллага өөрийн сайт болон интернэтэд дэлгэснээр сонирхсон хүн бүхэн орж үзэх боломж бүрдүүлэх тухай асуудал юм.

Мөн төсвийн болоод орон нутгийн өмчөөс санхүүждэг байгуулагуудаас гадна төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болон улсын үйлдвэрийн газруудын төсөв, санхүү ил тод болох бөгөөд энэ нь үр ашиггүй зардал, маргаан, шахааны бизнес зэрэг сөрөг үр дагаваруудаас зайлсхийх боломжийг олгох зорилготой юм.

“Шилэн данс” гэх эдийн засгийн хэллэг олон жил хэрэглэгдэж байгаа ч ийм байдлаар нэрлэгдсэн улсуудын мэдээлэл ховор юм. Дэлхийн улс орнуудад тусгайлсан бие даасан ийм нэртэй хууль бусад оронд байхгүй бөгөөд харин тэдгээрийн төсөв санхүүгийн эрх зүйг зохицуулсан хуулинд бүлэг юм уу эсвэл заалтаар хуульчилсан байдаг байна. Энэхүү хуулийн агуулгыг товчоор авч үзвэл шилэн дансанд төсвийн эрх захирагчдийн гаргаж буй мөнгө яг юунд зарцуулагдаж байгаа гэх шийдвэрийг нь илээр гаргаж тавьснаар төсөв, санхүүгийн нээлттэй хяналтын тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой.

Монгол Улсын төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангах, эрх зүйн нэгдмэл орчин бүрдүүлэх, татвар төлөгчдийн хөрөнгө болон төрийн өмчийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд захиран зарцуулах байдлыг журамлах, улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлжээ.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор анх баталж шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулж эхэлсэн. ба 2016 онд шилэн дансны цахим сайт шинэчлэгдсэнээр өмнөх журмыг хүчингүй болгож, 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

Хуулийн төсөл болон журмын төсөл боловсруулах үед Монгол Улс энэ талын туршлага сул, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль тогтоомжид тусгагдсан нээлттэй байдлын талаарх ойлголт нь тунхагийн шинжтэй хэн, хэзээ, хаана, хэрхэн, яаж хэрэгжүүлж, үр дүнг хэн хүртэх талаар тодорхой тусгаагүйгээс бусад хуулийн хүрээнд дараах байдлаар зохицуулагдаж

иржээ. Тухайлбал, үүнд:

- ✓ **Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1.17-д:**
 - “Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”,
- ✓ **Төрийн албаны тухай хуулийн 4.2.2-т :**
 - “төрийн алба ил тод байх”,
- ✓ **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5.1.3-т:**
 - “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”,
- ✓ **Төсвийн тухай хуулийн 6.5-д :**
 - “төсвийн ил тод байдлыг хангасан байх”
- ✓ **Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.1-д :**
 - “Төрөөс эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ”,
- ✓ **Улсын Их Хурлын 2012 оны 37-р тогтоолоор баталсан “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т :**
 - “Төр, засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авна” гэж тус тус заасан байна.

Засгийн газар, Сангийн яамны зүгээс “Шилэн дансны тухай” хуулийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хуулийн дагаж мөрдөх журам боловсруулан гаргаж, нэгдсэн цахим хуудсыг эрхлэн зохион байгуулж хуулийн хэрэгжилтийн хугацаанд олон улсын туршлагаас суралцан харьцуулалт, дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгч ажилласнаар хуулийн хэрэгжилт үр нөлөө жилээс жилд сайжирч байгаа ч цаашид улам боловсронгуй болгож хэрэгжүүлэх шаардлага тавигдсан хэвээр байна.

Нөгөө талаас энэхүү хууль хэрэгжиж эхлээд 4 жил болсон бөгөөд хуулийн зүйл, заалтыг тодорхой болгох, сайжруулах, төсөв, санхүүгийн ил тод байдлын талаар төрийн байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нэгмөр шийдвэрлэх, иргэд олон нийтийн оролцоог бодитойгоор бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаад байна.

Хуулийн хэрэгжилт, оноогийн нөхцөл байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Шилэн дансны тухай”**

хуулийг 2014 онд УИХ баталж 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнээр хуулийг дараах байгууллагууд хэрэгжүүлж байна. Үүнд:

- 1) Төрийн олон орон нутгийн өмчит хуулийн этгээд,
- 2) Төрийн өмчит үйлдвэрийн газрууд,
- 3) Хяналтын багц буюу түүнээс дээш хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани,
- 4) Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага
- 5) Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага, түүний эд хөрөнгө захирах зарцуулах эрх бүхий албан тушаалтнууд даган мөрдөж байна.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх ажлыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих*), Төрийн захиргааны удирдлагын газар (*www.shilendans.gov.mn цахим хуудасны хөгжүүлэлт, системийн тогтвортой үйл ажиллагаа*), Төрийн сангийн газар (*Шилэн дансны тухай хууль, журам, мэдээллийн төрөл, агуулгын талаарх арга зүй*) гэсэн 3 газар хариуцан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсанаар “Шилэн дансны тухай хууль” болон холбогдон гарсан журмыг олон нийтэд таниулан сурталчлах, мэдээлэл арга зүйгээр хангах ажлын хүрээнд бүх шатны хууль хэрэгжүүлэгч байгууллагууд (төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн бус байгууллага)-ын нийт 10000 орчим албан хаагчдыг хамарсан томоохон хэмжээний 82 удаагийн сургалтыг зохион байгуулж хууль, журмын эмхтгэл 10000 ширхэгийг хэвлүүлэн төсөвт байгууллагуудад хүргүүлж ажиллажээ.
2. Нийт 1000 гаруй улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2015 онд хуулийн хэрэгжилтийн явц цаашид анхаарах асуудлаар хэлэлцүүлгийг зохион байгуулж, Төрийн бус байгууллага /цаашид ТББ гэх/-уудын хуулийн хэрэгжилтэнд хийсэн дүн, судалгаа болон Үндэсний Аудитын Газар /цаашид ҮАГ гэх/ -ын тайланг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлсэнээр Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг хөгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хөгжүүлэлт хийгдэж 2016 оноос Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох тухай журмын шинэчилсэн найруулгыг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлуулсан байна.

3. Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар 2016-2017 онд аймаг, нийслэлийн Засаг даргын дотоод адитын нэгжийн ажилтнуудад шилэн дансны хяналтын талаар бүсчилсэн хэлбэрээр сургалт зохион байгуулжээ.
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг 2016 оны эхний хагас жилд багтаан ашиглалтанд оруулсанаар хууль хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн суурь бааз бий болж баазад мэдээлэл байршуулах, хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулах ажил хийгдсэнээр Шилэн дансны нэгдсэн мэдээллийн бааз бий болсон байна.
5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шинээр ашиглалтанд оруулсантай холбогдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт цахим буюу видео сургалтыг зохион байгуулж цахим хуудасны хөгжүүлэлтийг тасралтгүй хийснээр Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах төрийн болон орон нутгийн өмчит компаниудын бүртгэлийг ҮАГ, Төрийн өмчийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран эцэслэж, нэгдсэн системд тохиргоог хийснээр эдгээр байгууллагууд мэдээлэл байршуулах боломжоор хангагджээ.
6. Нэгдсэн системээс дотоод аудитын хэрэглэгчдэд зориулсан хяналтын тайланг боловсруулж бэлэн болгосноор бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудиторуудын харьяа байгууллагуудад хэрэгжүүлэх хяналтыг хялбаршуулсан зэрэг үр дүнтэй ажлууд хийгдсэн байна.
7. Иргэнд чиглэгдсэн хялбаршуулсан бүтцээр өгөгдлийг боловсруулах, мэдээлэл байршуулагч байгууллагын гар ажиллагааг хялбаршуулах үүднээс 2017 оноос хууль хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын бүртгэлийг хөтөлж, дүн шинжилгээ хийх зорилгоор зарим ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.
8. Сангийн яам Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг 2016 оны 6 дугаар сарын 30-ны дотор бүрэн ашиглалтад оруулсанаар шилэн дансанд тавигдсан мэдээллийг нэгтгэн дүгнэх боломжтой болсон байна.

Төрийн аудитын байгууллага ҮАГ нь “Шилэн дансны тухай хууль” 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш тус хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хэрэгжилтийн байдалд 2015, 2016, онуудад тус бүр 2 удаа, 2017, 2018 онд тус тус 1 удаа аудитыг гүйцэтгэж, тайланг Улсын Их Хуралд хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн.

ТББ-ын зүгээс тухайлбал “Нээлтэй нийгэм форум” хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2016 оноос хуулийн хэрэгжилтийн байдалд орон нутгийн ТББ-уудаар дамжуулан үнэлгээ хийх байдлаар бүх аймаг, нийслэл, сум дүүргийг хамруулан судалгаа хийж, тодорхой зөвлөмж, дүгнэлт, санал гаргаж

ирсэн байна.

2.1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас вэб сайтын талаар:

Сангийн яамнаас шилэн дансны нэгдсэн цахим системийг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд хуулийн үйлчлэлд хамаарах нийт 6,860 байгууллагын 40 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төслийн нэгж, ТӨҮГ, ТӨХК, ААНБ тус бүрээр мэдээллийн ангиллыг төрөлжүүлэн, мэдээлэл байршуулах хуульд заасан хугацааны давтамжийн тохиргоог мэдээлэл тус бүр дээр хийж тохируулсан бөгөөд байгууллага бүр мэдээллээ бөглөх, тайлагнах, татаж авах боломжийг бүрдүүлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн вэб хуудсаны хандалтын байдал:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2017-01-01 өдрөөс хойш нийт 151,917 хэрэглэгч 972,371 удаагийн хандалт хийж, 2,614,265 хуудасны мэдээллийг үзсэн байна. Цахим хуудсанд 96.6 хувь нь дотоодоос, 3.4 хувь нь гадаадаас хандсан байна.

Хүснэгт 1. www.shilendans.gov.mn хандсан хандалтын байдал

№	Нэгдсэн системийн үзүүлэлт	2016 он	2017 он	Нийт
1	Хандалтын тоо /1 хэрэглэгч давхардсан тоогоор/:	1,100,503	972,371	2,072,874
2	Үзсэн хуудасны тоо:	3,191,168	2,614,265	5,805,433
3	Нэг удаагийн хандалтаар дундажаар хэдэн минут зочилсон	5.32	4.37	4.84

Эх сурвалж: Сангийн яам.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хөгжүүлэлтийг тасралтгүй хийж ирсэнээр Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 54 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 4914 төсвийн байгууллага, 82 төслийн нэгж, Засгийн газрын болон орон нутгийн нийт 74 тусгай сан, 478 төрийн өмчийн үйлдвэр газар, 90 ТӨХК, төсвийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр ажил үйлчилгээ үзүүлж байгаа 1,222 ААНБ, нийт 6,860 байгууллагын 16,792 албан тушаалтан нэгдсэн системд 553,569 удаагийн хандалтаар олон нийтэд мэдээллээ тайлагнасан байна.

Хүснэгт 2. Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын статистик үзүүлэлт:

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Мэдээлэл оруулах эрхтэй хэрэглэгчийн тоо	Хуулийн үйлчлэл
1	Төсвийн байгууллага	4,914	12,664	3.1.1
2	ТӨХК, ОНӨХК	90	325	3.1.3
3	ТӨҮГ, УТҮГ, ОНӨҮГ	478	1,172	3.1.2
4	Төсөл, Хөтөлбөр	82	203	3.1.1
5	Засгийн газрын тусгай сангууд болон бусад сан	74	160	3.1.1
6	ТББ, Нөхөрлөл хоршоо, Аж ахуйн нэгж	1,222	2,268	3.1.4, 3.1.5
Нийт		6,860	16,792	

Эх сурвалж: Сангийн яам.

Төсвийн ерөнхийлөн захирагчдийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2017 оны IV улирлын байдлаар нийт 54 Төсвийн ерөнхийлөн захирагч болон ТББ, Нөхөрлөл хоршоо, ААНБ-ийн шилэн дансанд байршуулсан мэдээллийг хугацааны давтамжаар ангилан харуулбал:

Хүснэгт 3. Шилэн дансанд байршуулсан мэдээллийг хугацааны давтамж.

№	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэл	Мэдээлэлсэн	Хугацаандаа	Хугацаа хоцроосон	Хэрэгжилт
1	Бүтэн жилээр оруулах мэдээлэл	61,843	43,625	31,936	11,689	70.5%
2	Хагас жилээр оруулах мэдээлэл	21,440	20,035	16,711	3,324	93.4%
3	Улирал бүрийн мэдээлэл	28,748	25,652	18,332	7,320	89.2%
4	Сар бүрийн мэдээлэл	210,588	199,691	162,673	37,018	94.8%

5	Тухай бүрийн мэдээлэл	526,212	499,747	401,841	97,906	95.0%
	Нийт	848,831	788,750	631,493	157,257	92.9%

Эх сурвалж: Сангийн яам.

Дээрх хүснэгтээс харахад жилд нэг удаа мэдээлдэг санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, худалдан авах ажиллагааны тайлан зэргийг 51,4 хувийн гүйцэтгэлтэй хангалтгүй мэдээллэсэн бол тухай бүр мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг нь 95 хувь буюу хамгийн сайн мэдээлсэн байна.

Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт:

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагууд нийт 40 төрлийн мэдээллийг бүтэн жилээр, хагас жил, улирал, сар, 7 хоног тутам мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч 18 төрлийн мэдээлэл;
2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 10 төрлийн мэдээлэл;
3. Төсвийн байгууллага, төслийн нэгж 19 төрлийн мэдээлэл;
4. Төрийн өмчийн үйлдвэрийн газар 18 төрлийн мэдээлэл;
5. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдсэл сонирхолтой этгээд эзэмшиж байга компани 7 төрлийн мэдээлэл;
6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ нэг төрлийн мэдээллийг мэдээлэх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2017 оны IV улирлын байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллага, төрийн өмчийн аж нэгж байгууллага, гэрээний үндсэн дээр ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ийн шилэн дансанд байршуулсан мэдээллийг мэдээний төрлөөр ангилан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Шилэн дансанд байршуулсан мэдээллийг мэдээний төрлөөр

№	Байгууллагын төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлэсэн	Хугацаандаа	Хугацаа хоёрсон	Хүлээгдэж Хүлээгдэж
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	5,661	5,228	2,740	2,488	92.4%
2	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	4,876	4,437	3,366	1,071	91.0%
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	63,156	59,727	49,454	10,273	94.6%
4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт	810	483	317	166	59.6%
5	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	8,685	6,699	4,091	2,608	77.1%
6	Дараа жилийн төсвийн төсөл	5,574	4,788	3,264	1,524	85.9%
7	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	84,690	80,212	65,630	14,582	94.7%
8	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	7,239	6,307	4,738	1,569	87.1%
9	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	66,552	63,238	50,277	12,961	95.0%
10	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	72,423	68,564	55,388	13,176	94.7%
11	Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	7,676	6,745	5,193	1,552	87.9%

12	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	9,406	7,621	7,020	601	81.0%
13	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан	10,352	8,244	7,545	699	79.6%
14	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	63,744	59,438	47,429	12,009	93.2%
15	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	66,864	64,084	51,354	12,730	95.8%
16	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	62,160	60,062	46,125	13,937	96.6%
17	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	67,932	64,542	50,230	14,312	95.0%
18	Санхүүгийн тайлан	11,154	6,711	5,526	1,185	60.2%
19	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	5,576	1,530	1,509	21	27.4%
20	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	5,576	4,798	2,515	2,283	86.0%
21	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	66,840	63,356	52,988	10,368	94.8%
22	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	62,112	59,558	48,873	10,685	95.9%
23	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	66,840	63,400	52,692	10,708	94.9%
24	Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт	2	2	2	-	100.0%

25	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ	12	12	2	10	100.0%
26	Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын улирлын мэдээлэл	4	4	1	3	100.0%
27	Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан	2	2	1	1	100.0%
28	Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээ	4	4	1	3	100.0%
29	Засгийн газрын гадаад, дотоод өрийн улирлын мэдээлэл	4	4	1	3	100.0%
30	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны талаарх улирлын мэдээлэл	4	4	2	2	100.0%
31	Концессийн мэдээлэл	1,032	949	653	296	92.0%
32	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцооны улирлын мэдээлэл	4	4	2	2	100.0%
33	Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл	360	360	285	75	100.0%
34	Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл	1,068	937	637	300	87.7%
35	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл	4,800	3,416	1,819	1,597	71.2%
36	Улсын концессийн мэдээлэл	12	12	1	11	100.0%
37	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	5,291	4,697	3,533	1,164	88.8%
38	Худалдан авах ажиллагааны тайлан	5,664	4,263	4,053	210	75.3%
39	Дараа жилийн төсвийн төсөл (Улсын хэмжээнд)	12	2	1	1	16.7%
40	Байгууллагын батлагдсан төсөв	4,658	4,306	2,235	2,071	92.4%
	Нийт	848,831	788,750	631,493	157,257	92.9%

Эх сурвалж: Сангийн яам.

Нэгдсэн системээс дотоод аудитын хэрэглэгчдэд зориулсан хяналтын тайланг боловсруулж бэлэн болгосноор бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудиторуудын харьяа байгууллагуудад хэрэгжүүлэх хяналтыг хялбаршуулж Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг хуулийн дагуу эрхлэн хөтөлж хууль хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн суурь баазаар хангах боломжийг бүрдүүлсэн байна.

Хуулийн хэрэгжилт, хүрсэн үр дүн

Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд мэдээлэгдснээр төсвийн ил тод байдлыг хангагдаж иргэдийн төсвийн хэрэгжилтэнд хяналт тавих нөхцлийг бий болгож байгаа нь уг хуулийн үндсэн зорилт хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна. Хууль хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Төсвийн ил тод байдал
- Иргэн татвар төлөгчдийн хяналтын тогтолцоо
- Төсвийн сахилга бат, хариуцлага
- Төрийн санхүүгийн мэдээллийн цогц үйлчилгээ бүрдсэн байна.

Гэвч нэгдсэн системээс хуулийн хэрэгжилтийн талаар авсан нэгдсэн мэдээллээс харахад хуулийн хэрэгжилтийн статистик хангалттай түвшинд хүрээгүй байна. Нэгдсэн цахим хуудсанд хууль хэрэгжүүлэхээр үүрэг олгогдож бүртгэгдсэн байгууллагын 54,6 хувь нь шилэн дансны мэдээллийг хугацаандаа тайлагнаж ажилласан бол үлдсэн 45.4 хувь нь хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн дүнтэй байна.

Хүснэгт 5. Нэгдсэн системээс хуулийн хэрэгжилт.

ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛАГУУД	Нийт байгууллага	Мэдээлэл зохих мэдээллийн оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:		Гүйцэтгэл
				Хугацаандаа	Хоцорсон	
Төсөвт байгууллага	4980	243388	166625	138874	27751	65.4%
Төрийн Бус байгууллага	26	67	35	22	13	52.2%
Нөхөрлөл , Хоршоо	206	1032	646	544	102	62.6%
Аж Ахуй Нэгж	910	1314	444	365	79	43.7%
Төсөл, Хөтөлбөр	84	4004	1885	1321	564	47.1%

Төрийн Өмчит Аж Ахуй Нэгж Байгууллага	71	3150	1577	906	671	50.1%
Хувь оролцоотой болон ТӨХК	93	1578	1154	765	389	73.1%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	137	6327	4025	2858	1167	63.6%
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	135	6231	3967	2756	1211	63.6%
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	142	6325	3312	2449	863	52.4%
Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	30	1358	463	345	118	34.1%
Засгийн газрын тусгай сан	76	3678	1936	842	381	47.9%
НИЙТ ДҮН	6890	278452	186069	152047	33309	54,6%

Эх сурвалж: Сангийн яам.

Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцлийг судлан үзэхэд: интернэтийн үйлчилгээ авах боломжгүй сум суурин газрууд шилэн дансны мэдээлээ мэдээллийн самбарт байршуулаагүй, зарим байгууллага нь шилэн дансанд холбогдох ажил үйлчилгээ гараагүй тул мэдээлээгүй үлдсэн хэсэг нь мэдээлэл оруулаагүй боловч тайлбар тодруулга өгөөгүй, сумдад интернэтийн хурд хангалтгүйн улмаас мэдээллийг оруулах боломж хязгаарлагдмал, хугацаа хоцорч мэдээлээ оруулдаг зэрэн нийтлэг шалтгаантай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Нэгдсэн системээс хуулийн хэрэгжилтийн талаар авсан нэгдсэн мэдээллээс харахад төсвийн ерөнхийлөн захирагч нарын шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн үнэлгээний дүнгээс харахад олон нийтэд мэдээлэл хүргэх, мэдээлэл байршуулах асуудал хангалттай түвшинд хүрээгүй байна.

Нийт хууль хэрэгжүүлэгч 6,860 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар 788,750 мэдээллийг олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд эдгээр байгууллагууд 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 848,831 мэдээллийг мэдээлэх бөгөөд хэрэгжилт дунджаар 77,3 хувьтай байна.

Шилэн дансны хэрэгжилтэнд хийгдсэн хяналт шалгалтын талаар

Төсвийн тухай хуулийн 69.3. “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон

нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэсний дагуу дээрх байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд Сангийн яам, Үндэсний Аудитын Газраас хяналт тавин ажиллаж байна.

Улс болон аймаг нийслэл, сум дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилтэнд 2016, 2017, 2018 онд тус тус аудитын хийгдсэн байна.

Үндэсний аудитын газраас 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд аудит хийж, Монгол Улсын Ерөнхий сайдад 3 зөвлөмж, Сангийн сайдад 2 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх аудитуудаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх талаар жил бүр тайлагнаж ажилладаг хэдий ч зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Нөгөөтэйгүүр хууль, журмын үг хэллэг хоёрдмол утга санааг агуулсан заалтууд байх тул хууль хэрэгжүүлэгчийн түвшинд ойлголтын зөрүү үүсэх эрсдэл байна. Түүнчлэн шилэн дансны нэгдсэн программ хангамжийн зохион байгуулалт хангалттай түвшинд бус уялдаатай ажиллах дагалдах програм хангамжийн ажиллагаа хэвийн бус байгаа зэрэг нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлжээ.

Зураг 1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдал



Эх сурвалж: Сангийн яам, ҮАГ.

Агентлагуудын статус, төсөвтэй харьцдаг харьцааг нарийвчлан тогтоож өгөөгүйгээс Засгийн газрын зарим хэрэгжүүлэгч агентлагууд төрийн үйлчилгээ үзүүлсэний хураамж, ажил үйлчилгээний зөвшөөрөл олгож үлэмж хэмжээний орлого олж ашигтай ажиллаж байна.


Гэтэл эдгээр байгууллагууд нь төсөвтэй хэрхэн харьцах, татвар хураамж

ямар хэмжээгээр төлөх талаар тодорхой зохицуулалтгүй байна. Энэ байдлаас шалтгаалан улсын төсөвт төвлөрөх хөрөнгийн боломжийг алдахын зэрэгцээ тухайн байгууллага үрэлгэн хандах, орлогыг зориулалтын бус зүйлд зарцуулах, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өөрсдийн үзэмжээр дур мэдэн зарцуулах, цалин хөлс шагнал урамшуулаа төрийн албан хаагчийн жишгээс өндөр тогтоох, гар утас, унааны зардлаа нэмэгдүүлэхэд түлхүү зарцуулж байна.

Төсвийн байгууллагууд тусгай сангийн болон нэмэлт санхүүжилтын дансны мэдээллийг шилэн дансны сайтад бүрэн байршуулахгүй байна. Төр хувийн хэвшлийн компаниудын үйл ажиллагааны статусын зөрчилтэй байдлаас шалтгаалж үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв бодитой тооцох боломжгүй болсон байна. Энэ байдлаас шалтгаалж шилэн дансны хуулийн үйлчлэлд хамаарах зарим байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл тодорхой тусгагдахгүй байна.

Тухайлбал 2016, 2017 онд ҮАГ-аас Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилтэнд хийсэн судалгаатай харьцуулахад дараах байдалтай байна.

Зураг 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилт



Эх сурвалж: ҮАГ-ийн аудитын тайлан

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4.” улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ,

ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;”

- 3.1.5. “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч” байгууллагууд энэ хуулийн үйлчлэлд хамаарна гэж заасан байна.

Гэтэл Нийгмийн даатгалын сан болон Хүний хөгжил сан, Орон нутгийн хөгжлийн сан, Засгийн газрын тусгай сангууд, төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл, баталгаа зэрэг төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа үйл ажиллагаа, Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын асуудлыг хуульд заасны дагуу бүрэн хэмжээгээр байршуулахгүй байна.

Шилэн дансны тухай хуулинд төрийн нууц, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагаа хамаарахгүй байхаар заасан боловч энэ чиглэлийн мэдээллийг тодорхой хуульчлан зааж өгөөгүйгээс шалтгаалж шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулах үндэслэл болж байна.

Төрийн бодлогын гажуудлаас шалтгаалж Төрийн өмчит үйлдвэр нэгжийг үр ашигтай ажиллуулах талаар төрийн зохицуулалтын нэгдсэн бодлого байхгүй байгаа нь төсөвт төлөх татвар хураамжаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх бодит боломжийг алдагдуулж байна. Хуулиар зохицуулбал зохих харилцааг эрхзүйн тодорхой зохицуулалтгүй орхигдуулсан нь салбарын эрхзүйн орчинд тодорхойгүй байдлыг бий болгож төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааны статус харьяаллыг тодорхой тогтоогүйгээс ногдол ашгаа тогтоосон хувь хэмжээгээр төсөвт төвлөрүүлэхгүй байна

Шилэн дансны мэдээллийг байгууллага аж ахуйн нэгжүүд мөрдөж ажиллаж байгаа боловч байгууллагын үйл ажиллагааны орлого, зардал эдийн засгийн үзүүлэлтүүдийг бүрэн хамааруулж тайлагнахгүй байгаагаас Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчил дутагдал гарсаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцоон дээр бие даан ажиллуулдаггүй, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний өртөгийг харьяа яамдаас тогтоон өгч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь улсын төсвийн санхүүжилтээр худалдан авч байгаа боловч үнийн судалгаа хийж зах зээлийн үнийн түвшинтэй харьцуулалт хийдэггүй, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль дүрмийг зөрчсөн, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ өөрийн өртгийг тооцдоггүй зэргээс шалтгаалж балансаар гарсан борлуулалт, цэвэр ашгийн хэмжээг бууруулан зардлаа нэмэгдүүлэн тооцож хууль бусаар

ашиглаж байна.

Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй 55.000 гаруй компани байдаг бөгөөд Хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй компани 0.5%-г эзэлж байна.

- 2016 оны байдлаар нийт 54.844 компани үйл ажиллагаа явуулж буйгаас 99,5% буюу 54586 нь Хязгаарлагдмал хариуцлагатай, 0,5% буюу 258 нь Хувьцаат компани байна.

Гэтэл³ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйл 2-д зааснаар Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустайгаар ажиллаж байгаа орон нутгийн болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд өөрийн үйл ажиллагааны орлогыг улсын төсвийн хөрөнгөөр болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр бүрдүүлж Засгийн газар яам агентлагаас зарласан тендерт давуу эрхтэйгээр оролцож олсон орлого болон төсвийн санхүүжилтээр бүрдүүлж олсон ашгаасаа шагнал урамшил олгох, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, зээлийн баталгаа, болгох зэргээр зориулалт бусаар зарцуулдаг зөрчил нийтлэг байна.

Төрийн өмчит хуулийн этгээдэд хамаарч байгаа эдгээр байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу мэдээллээ цахим сайтад байршуулахаар заасан байна. Үүнд

- 3.1.1. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
- 3.1.2. төрийн өмчит үйлдвэрийн газар;
- 3.1.3. хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;
- 3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;
- 3.1.5. төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд хамаарч байна.

Гэтэл Шилэн дансны хуулийн хүрээнд дээрх байгууллагууд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, дансны мэдээллээ бүрэн байршуулахгүй байгаагаас дараах нийтлэг зөрчил гарч байна.


Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйлдвэрлэлийн болон худалдан авалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн хорооноос хянаж баталгаажуулж байгаа боловч үйлдвэрийн газрууд үйлдвэрлэх бүтээгдэхүүнийхээ гэрээг харьяа агент-лагуудтай хийж байгаа нь дээрх баталсан төлөвлөгөөтэй уялдахгүй байгаагаас гадна гүйцэтгэлээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо

³ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

хэмжээ, орлого үр дүнг санхүүгийн тайланд хуурамчаар гаргаж борлуулалт, цэвэр ашиг, зардлын үзүүлэлтийг буруу тооцож хууль тогтоомжийг зөрчиж байна.

Гэвч эдгээр байгууллагууд Санхүүгийн хяналт шалгалт болон Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зураг 3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдал.



Эх сурвалж. ҮАГ аудитын тайлан.

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд санхүүгийн сахилгыг зөрчиж хууль тогтоомжийг бүрэн хэмжээгээр мөрдлөг болгож ажиллаагүй, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих байгууллагын дотоодын хяналт сул, өмч хөрөнгөд дураар хандах хандлага түгээмэл байгаа нь санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрч байгаа төлбөр зөрчлийн судалгаанаас харагдаж байна.

Сангийн сайдын удирдамжийн хүрээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн дотоод аудитаар сайдын багцад хамаарах байгууллагуудын хуулийн хэрэгжилт 2018 оны 2-р улирлын байдлаар 87%-ийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Гэвч дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

Байгууллагууд шилэн дансны системд мэдээлэл байршуулахдаа хэлбэр төдий буюу сард нэг удаа нэг мэдээлэл оруулж байна. Тухайлбал: төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэр сард 5-10 удаа гарч байхад зөвхөн 1 мэдээлэл байршуулсан;

Шилэн дансны хууль, ил тод байдлын ач холбогдол, үүрэг хариуцлагын талаарх байгууллагын дарга, нягтлан бодогч нарын мэдлэг хангалтгүй;

Зарим байгууллага тухайлбал төслийн нэжүүдийн хувьд мэргэжлийн нягтлан бодогч бус хүнд шилэн дансны мэдээллийг хариуцуулсанаас шалтгаалж мэдээлэл дутуу тайлагнагдаж байгаа зэргээс шалтгаалж хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар улс орон нутгийн төсвийн болон төрийн өмчит байгууллагад 2017 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 316.3 тэрбум төлбөр зөрчил илэрсэнийг зөрчлийн ангиллаар нь авч үзвэл дараах байдалтай байна.



Эх сурвалж: Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын тайлан. 2016-2017.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн судалгааны дүнгээс харахад Санхүүгийн шалгалтад хамрагдаж байгаа байгууллагын тоо нэмэгдэж шалгалтын мөрөөр ажиллаж байгаа зэрэг ажлын нааштай зүйлүүд байгаа хэдий ч шалгалтаар илэрсэн төлбөр зөрчил нь дан ганц бүртгэл хөтлөлтийн байдлаас ч бус хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлаас хамаарч байна.

Энэ нь шилэн дансны мэдээллийг илүү боловсронгуй болгож төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг улам бүр нээлттэй ил тод болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг бүтцийн хувьд авч үзвэл:


1. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан мэдээний асуудалтай холбоотой зөрчил дутагдал давтагдсаар байна. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгж төсвийн байгууллагууд хөрөнгө мөнгийг данс бүртгэлд тусгалгүй орхигдуулах, өр авлагыг үндэслэлгүй хаах бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж хөрөнгө мөнгийг зарцуулсан, түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй

зэрэг хууль бус үйлдэл илэрч байгаа нь жилийн нийт төлбөрийн 27.7 %-ийг

2. Улсын төсөв, нэгдсэн санд төвлөрүүлбэл зохих татвар шимтгэлийг дутуу ногдуулсан, хугацаанд нь төлдөггүй, тооцож авдаггүй зэрэг зөрчил дутагдал 11,8 %-ийг
3. Төрийн өмчийн болон төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, зориулалт бусаар ашиглах, бусдад түр хугацаагаар ашиглуулах, зэрэг төлбөр зөрчил нийт төлбөрийн 21,8 %-ийг дутуу болон илүү олгосон цалин хөлс 5,4 %-ийг хувийг, нөхөн олговор, 6,5 %-ийг эзэлж байна.
4. Төрийн өмч, төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан, төсвийн хөрөнгийг бусдад ашиглуулж дутагдуулсан зөрчил, 7 %-ийг бусад холбогдох хууль, тогтоомж, журмыг зөрчсөн зөрчлүүд 5,7 %-ийг эзэлж байгаа нь төсвийн хөрөнгийн ашиглалт зарцуулалтанд тавих байгуулагын дотод хяналт сул, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хуулиудын хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн сахилга зөрчигдөж байгааг харуулж байна.

Тухайлбал 2016, 2017 онд УАГ-аас орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилтэнд хийсэн судалгаатай харьцуулахад дараах байдалтай байна.

Зураг 5. Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилт



Эх сурвалж: УАГ-аудитын тайлан 2016-2017.

Төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөж байгаа зарим хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн судалгаанаас харахад хууль

тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг албан тушаалтнууд өөрсдөө хуулиа зөрчдөг байдал нийтлэг байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлэхэд үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу бүх шатны ИТХ, ИНХ-аас шилэн дансны хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналт хангалтгүй, эрх бүхий байгууллагууд хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зураг 6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал.



Эх сурвалж: ҮАГ-аудитын тайлан 2016-2017.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчлийн хэмжээ нэмэгдэж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, хуулиар эрх олгоогүй байхад өөрсдийн дураар дүрэм, журам тогтоож өөртөө давуу эрх олгосон, эрх хэмжээгээ хэтрүүлж төрийн өмч, төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан зэрэг зөрчил дутагдал нийтлэг байгаа нь Санхүүгийн зөрчлийг захиргааны зөрчлөөс ялган зүйлчилж хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

Санхүүгийн эрхзүйн хүрээнд өөр хоорондоо уялдаа холбоо муутай хуулийн заалтууд, улсын бүртгэлд хянан бүртгүүлээгүй, салбар яамдын дүрэм журмаар батлагдсан өөртөө хууль тогтоомжоос илүү эрх хэмжээ бий болгосон эрхийн актууд, амьдралаас тасархай хэрэгжих боломжгүй дүрэм журмууд үйлчилж байгаа ч үүнийг хууль тогтоомжид нийцүүлэн нэг мөр цэгцлэх, тухайн салбарын эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүйгээс энэ хүрээнд гарсгасан тушаал шийдвэрийн үйлчлэлээс хамаарч хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар

зарцуулах үндэслэл болж байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд Санхүүгийн хяналт шалгалтын албаны бүх шатанд хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж санхүүгийн шалгалтаар тогтоогдсон төлбөр зөрчлийн барагдуулалт түүний мөрөөр зохиох ажлыг сайжруулах, санхүүгийн зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх шалгалтын дүнг нийтэд мэдээлж шилэн дансанд байршуулах, ил тод сурталчилж үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой гэж үзэж байна.

Хуулийн хэрэгжилтийн байдал 2018 онд дараахь байдалтай байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааг 2018 оны 3 дугаар улирлын байдлаар улсын төсвийн ТЕЗ-д, тэдгээрийн харьяа байгууллагууд 86.7 хувь, Аймаг, нийслэлийн ТЕЗ, тэдгээрийн харьяа байгууллагууд 86.2 хувь хэрэгжүүлсэн байна.

Улсын төсвийн 32 ТЕЗ, тэдгээрийн харьяа 869 байгууллага, Аймаг нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4079 байгууллага буюу нийт 4948 байгууллагаас 4584 байгууллагыг түүвэрт хамруулан, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь ШДНЦХ-т байршуулсан эсэх шалгасан байна.

Сангийн яамнаас гаргасан мэдээгээр 2018 онд 3 улирлын байдлаар Иргэд, олон нийт 2018 онд 3 дугаар улирлын байдлаар ШДНЦХ-т 324,578 удаагийн хандалтаар 2,675,397 мэдээлэлтэй танилцаж, байгууллагуудын мэдээлэл байршуулах чиг үүрэх бүхий албан хаагчид 413,183 удаагийн хандалт хийж холбогдох мэдээллийг ШДНЦХ-т байршуулсан байна.

ҮАГ-ын Шилэн дансны тухай хуулийн 2018 оны хэрэгжилтийн байдал хийсэн аудитаар дараахь дүгнэлтүүд гарсан байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах улсын төсвийн ТЕЗ-дийн харьяа 869 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 86.1 хувь, аймаг нийслэлийн төсвийн ТЕЗ-дийн харьяа 4079 байгууллагын хэрэгжилт 88.7 хувь байна.
2. Хуульд заасан мэдээллийг ШДНЦХ-т бүрэн мэдээлээгүй зөрчлийг гаргаж төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаагүй 467 байгууллагад зөрчил арилгуулах, холбогдох 37 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг тус тус өгсөн.
3. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөр болон Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааг ил тод мэдээлэх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.
4. Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тогтоогоогүйгээс Аймаг, нийслэл дэх ТЕЗ-дын харьяа байгууллагууд мэдээллийн самбартаа

хуульд заасан мэдээллийг байршуулаагүй зөрчил байна.

ШДНЦХ-ны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс *www.tender.gov.mn* сайтад мэдээллийг давхардуулж байршуулдаг, мэдээлэл байршуулах цэс бусад төсөв, санхүүгийн төлөвлөх, тайлагнах загвар маягтуудтай уялдаагүйгээс мэдээллийг гараар шивж оруулдаг зэргээр ажлын хэт ачаалал үүсгэдэг, байгууллагуудын хөтөлж байгаа цэс нь зөрүүтэй үүсгэгдсэн зэрэг зөрчилтэйгээс хуулийн 4 дүгээр зүйлд заасан “*мэдээлэл цнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх*” зарчим бүрэн хэрэгжихгүй байна.

5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй, **төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгчид хуульд** заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүйтэй холбоотой байна.
6. Хуулийн хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн арга зүйн зохицуулалтгүй, дотоод аудитын нэгжийн албан хаагчид хууль, холбогдох журмын талаар харилцан адилгүй ойлголт, мэдээлэлтэйгээс дотоод хяналт үр нөлөөгүй байх эрсдэлтэй байна.
7. Хуулийн хэрэгжилтэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын хөндлөнгийн хяналтын чиг үүрэг хангалтгүй, баг, хорооны ИНХ-аас хөндлөнгийн хяналтыг огт хэрэгжүүлдэггүй байна.
8. Иргэд, олон нийт 2018 онд 3 дугаар улирлын байдлаар ШДНЦХ-т 324,578 удаагийн хандалтаар 2,675,397 мэдээлэлтэй танилцаж, байгууллагуудын мэдээлэл байршуулах чиг үүрэх бүхий албан хаагчид 413,183 удаагийн хандалт хийж холбогдох мэдээллийг ШДНЦХ-т байршуулсан байна.
9. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувь байна.

Шилэн дансны хуулийн хүрээнд тулгамдаж буй асуудлууд

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад тулгамдаж буй асуудлын талаар хийсэн судалгааны дүнг нэтгэн дараах байдлаар ангилан авч үзлээ. Үүнд:

Хууль эрх зүйн орчинд гарч буй бэрхшээл

Шилэн дансны тухай хууль, журам нь иргэн болоод хэрэгжүүлэгч байгууллагад хялбаршуулан энгийн ойлгомжтой байдлаар зохион байгуулагдаагүй мэргэжлийн үг хэллэг ихтэй ач холбогдол сул нилээд их хэмжээний өгөгдлийн

сан бүрдэхээр зохицуулагдсан байна.

Зураг 6. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Хуульд заасан мэдээлэл иж бүрэн, ойлгомжтой байх зарчмын шаардлагыг хангахгүй, олон нийтийн зүгээс мэдээлэлтэй танилцах болон хөндлөнгийн хяналтын байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэсэн байна. **Шалтгаан:**

- ЦАХИМ ХУУДАСНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС МЭДЭЭЛЭЛ ЦЭГЦҮЙ, ОЙЛГОМЖГҮЙ
- НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТАЙ ДАВХАРДУУЛАН МЭДЭЭЛДЭГ НЬ -АЖЛЫН АНААЛАЛ ҮҮСГЭДЭГ
- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ ШИЛЭН ДАНСНЫ АХИМ ХУУДАС БОЛОН WWW.TENDER.GOV.MN ХАЯГААР ДАВХАР МЭДЭЭЛДЭГЭЭС АЖЛЫН - АНААЛАЛ ҮҮСГЭЖ МЭДЭЭЛЭЛ ДУТУУ БАЙРШИГДАГ
- МЭДЭЭЛЖ БҮЙ АЛБАН ТУШААЛТНУУД ӨӨРИЙН ЦАХИМ ХУУДАСТ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ МЭДЛЭГ, УР ЧАДВАРГҮЙ БАЙГААГААС МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТНЭЭР ДАМЖУУЛАН МЭДЭЭЛЛЭСНЭЭС ХУГАЦААНДАА, ТОГТМОЛ МЭДЭЭЛЭГДДЭГГҮЙ

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-д хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч байгууллага татан буугдсан байхад бүртгэлээс хасагдаагүй, зарим байгууллагын цэс давхар үүсгэгдсэн;

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах 1206 байгууллагын цэс үүсгэгдсэнээс үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 382 аж ахуй нэгж, байгууллага бүртгэлтэй байна.

Хуулийн зөрчил нь ТЕЗ-аас 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад хүндрэл үүсгэж байгаа тул Шилэн дансны тухай хуулийн дээрх заалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

Хуулийн 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй нийтлэг зөрчилтэй

- Хяналт тавих байгууллага болон албан тушаалтан байхгүй
- Хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна.

Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно. Хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудлууд нь

Иргэдийн оролцоо сул байгаагаас системийн хэрэглээ сулрах хандлагатай, мэдээлэл байршуулж байгаа ажилтны ажлыг бүрэн автоматжуулах боломж бага байгаа зэрэг зөрчлүүд байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хөгжүүлэлт хангалтгүй байна.

Цахим мэдээллийг нягтлаж үзэхэд байгууллагын нэр, хариуцлагын болон өмчийн хэлбэр тодорхойгүй, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэхгүй, мэдээллийн өгөгдлийг бүрэн гүйцэд оруулаагүй, зарим гүйлгээний утга тодорхой бус, шийдвэрүүдээ дутуу мэдээлсэн зэрэг нь олон нийт мэдээллийг цогц байдлаар авах нөхцөлийг бүрдүүлээгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал сөрөг хандлагууд гарч байна.

Үндэсний аудитын газраас 2015, 2016 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитаар өгсөн 6 зөвлөмжийн дийлэнх нь хуульд зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах тухай зөвлөмж өгөгдсөн байгааг анхаарах нь зүйтэй юм.

Дүгнэлт.

Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд мэдээлэгдсэнээр төсвийн ил тод байдал хангагдаж иргэдийн төсвийн хэрэгжилтэнд хяналт тавих нөхцлийг бий болгож байгаа нь уг хуулийн үндсэн зорилт хэрэгжиж байна гэж үзэж байна.

Цахим мэдээллийг нягтлаж үзэхэд байгууллагын нэр, хариуцлагын болон өмчийн хэлбэр тодорхойгүй, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэхгүй, мэдээллийн өгөгдлийг гүйцэд оруулаагүй, зарим гүйлгээний утга тодорхой бус, шийдвэрүүдээ дутуу мэдээлсэн зэрэг нь олон нийт мэдээллийг цогц байдлаар авах нөхцөлийг бүрдүүлээгүй шалтгаан болж иргэдийг төөрөгдүүлэх сөрөг хандлагууд гарч байна. Цаашид төсвийг зүй зохистой зарцуулах, татвар төлөгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга бат, хариуцлага, дотоод хяналтыг дээшлүүлэх нь чухал байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн хяналт шалгалтын тогтолцоо, чиг үүрэг улсын салбарын дотоод аудитын стандартыг олон улсын хэмжээнд хэрхэн мөрдөж хэрэгжүүлж байгааг шилэн дансны тогтолцоотой уялдуулж гадаад орнуудын эрх зүйн эх сурвалжуудтай харьцуулан судалж дараах чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах Үүнд:

Төсвийн зарцуулалтыг ил тод болгох асуудлыг (Швейцар, Норвеги, Сингапурын жишгээр) санаачлан боловсруулж батлуулах;

- ❖ Санхүүгийн зөрчлийг захиргааны зөрчлөөс ялган зүйлчлэх хандлагыг хөгжингүй орны жишгийн дагуу бий болгон онол практикт нэвтрүүлэх
- ❖ Төсөв, татвар, өмч, даатгал, хөрөнгийн зах зээл, санхүү, бүртгэлийн хууль тогтоомжийг хоорондоо уялдаа бүхий оновчтой бөгөөд тогтвортой үйлчлэх нөхцлийг хангаж эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
- ❖ Нягтлан бодогч санхүү, бүртгэлийн ажилтны санхүүгийн сахилга

хариуцлагыг өндөржүүлж санхүүгийн хууль тогтоомжид процессын журмыг нэвтрүүлж ,эрхзүйн орчинг оновчтой болгох.

- ❖ Санхүүгийн зарим ноцтой зөрчлүүдийг гэмт хэрэгт тооцон зүйлчилж Эрүүгийн хууль тогтоомжид нэмж тусгах асуудлыг судалж боловсруулах / Санхүүгийн баримт хуурамчаар бүрдүүлэх, төсвийг зүй бусаар зарцуулах, хуваарилалтыг дур зоргоох хийх/

Үндэсний аудитын газраас 2015, 2016 он, 2017 онуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитаар өгсөн 11 зөвлөмжийн дийлэнх нь хуульд зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах тухай зөвлөмж өгөгдсөн байгааг анхаарах нь зүйтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагуудын өөрийн цахим хуудаст оруулах мэдээллийн давхардлыг арилгаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлын хүрээнд Засгийн газраас дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Мэдээлэл тавих эрх бүхий албан тушаалтнуудыг нэгдсэн арга зүйгээр хангах, сургалтыг зохион байгуулах замаар шилэн дансанд байршуулж байгаа мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг сайжруулах;
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд багтаан мэдээллийг тогтмол оруулж хэвшүүлэхэд хуулийн хүрээнд хамрагдах бүх байгууллагууд анхаарч ажиллах;
3. Тайлан ирүүлээгүй Төсвийн ерөнхийлөн захирагч нар тайланг цаг хугацаанд нь ирүүлж байх талаар анхаарч ажиллах;
4. Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийн хяналтыг сайжруулж, хууль хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;
5. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг сайжруулах;
6. ХШҮ-ний нэгж, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын нэгжүүд болон дээд байгууллагаас хийгдэх аливаа ХШҮ, хяналт, шалгалт, аудит хийхдээ удирдамж болон тайланд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар бүлэг болгон тусгаж байх.
7. Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэх.

Хуулийн гол зөрчил нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас Шилэн дансны тухай хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад хүндрэл үүсгэж байгаа тул дээрх заалтуудыг Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж болгох нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, мэдээллийн тайлагналтын журмыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төрийн аудитын байгууллагатай хамтран боловсруулах.
2. Шилэн дансны тухай хууль, холбогдох журам шинчлэгдэн батлагдсаны дараа нэгдсэн цахим хуудсны хөгжүүлэлтийг хийх.
3. Мэдээллийн төрлийг ойлгомжтой, энгийн болгох.
4. Хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгох (Төсөвт байгууллага, ТӨХК, ОНӨААТҮГ, ХХК, ТББ, холбоо, Олон нийтийн байгууллага, төсөл, сан)
5. Хуулийн хариуцлага хүлээлгэх эрхзүйн үндсийг тодорхой болгох. (ТҮ болон ТӨХК-ийн ажилтнуудад ямар хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгах.)
6. Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн данс болон төсөл арга хэмжээ, бусад дансны мэдээллийг шилэн дансанд ил тодоор мэдээлж байх.
7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлэхэд үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах
8. Төсвийн ерөнхийлөн захирагчдийн дотоод аудитын нэгж Шилэн дансны тухай хуульд заасан дотоод аудит хийсэн талаарх мэдээллийг цахим сайтад нээлттэй мэдээлж байх.
9. Цаашид төсвийг зүй зохистой зарцуулах, татвар төлөгчдийн итгэлийг бүрдүүлэх, төсвийн сахилга бат, хариуцлага, дотоод хяналтыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.
10. Шилэн дансны системийн хөгжүүлэлтийг үргэлжлүүлэх.
11. Шилэн дансны системд хангалтгүй тайлагнасан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зээлийн мэдээллийг тодорхой болгох, ЖДҮХСан болон Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны хэрэгжилт зээл олголтын асуудлыг төсөл сонгон шалгаруулалтаас эхлэн шилэн дансанд нээлттэй мэдээлж байна.

Ашигласан материал:

- [1] Үндэсний аудитын газраас 2015, 2016, 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудит
- [2] Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас (Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн хяналт хяналт шинжилгээ, үнэлгээ)
- [3] Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас /

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн судалгаа ажлын тайлан /

- [4] Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн судалгаа, дүгнэлт
- [5] Шилэн дансны тухай хууль 2015 он.
- [6] Төрийн хяналт шалгалтын тухай хууль. “Төрийн мэдээлэл”. 2012. № 28
- [7] “Нийгмийн даатгалын тухай “хууль 2013 он шинэчилсэн найруулга
- [8] “Төсвийн тухай хууль”-ийн 2013 он шинэчилсэн найруулга
- [9] “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”. 2012 он шинэчилсэн найруулга
- [10] “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль 2012 он
- [11] Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” 2010 он
- [12] Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 2010 он шинэчилсэн найруулга